

БУЛГАН АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БУА-2022/129/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Булган хот
2022 он

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр
Утас: 70342580 Цахим хаяг: ankhbayard@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 70342716 Цахим хаяг: enkhthoodolj@audit.gov.mn

Аудитор: Б.Пүрэвсүрэн
Утас: 70353717 Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2-3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
4. Аудитын илрүүлэлт	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УЕПГ	Улсын ерөнхий Прокурорын газар
БАПГ	Булган аймгийн Прокурорын газар

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

63082 Булган аймэг, Булган сум, Жаргалант баг,
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2022.02.25 № 29

тантай _____ -ны № _____ т

Зөрчилгүй дүгнэлт

ПРОКУРОРЫН ГАЗРЫН ДАРГА
Н.МӨНХНАРАН ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Прокурорын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Прокурорын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

D:\ichigheg\2022A\foot

006009613

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

D:\aichig\ereg\2022\44\toot

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/			
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	12,210,574.00	19,171,325.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	676,500.00	00.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	676,500.00	00.00
3121	Төгрөг	676,500.00	00.00
31211	Төрийн сангийн харилцах	676,500.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	11,534,074.00	19,171,325.00
354	Хангамжийн материал	11,534,074.00	19,171,325.00
35410	Бичиг хэргийн материал	1,334,300.00	1,503,900.00
35420	Аж ахуйн материал	7,842,774.00	9,749,458.00
35430	Сэлбэг хэрэгсэл	440,000.00	00.00
35440	Түлш, шатах тослох материал	350,000.00	00.00
35450	Барилгын засварын материал	1,567,000.00	3,480,000.00
35470	Бусад хангамжийн материал	00.00	4,437,967.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	232,589,888.60	258,932,721.06
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	232,589,888.60	258,932,721.06
391	Газар	00.00	00.00
392	Биет хөрөнгө	200,879,888.60	227,222,721.06
39201	Барилга, байгууламж, орон сууц	100,377,870.00	100,377,870.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-6,502,462.32	-9,753,693.48
39203	Авто-тээврийн хэрэгсэл	127,200,000.00	121,700,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-82,366,666.64	-85,833,333.28
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	55,070,055.59	92,544,143.59
39206	Хуримтлагдсан элэгдэл	-16,574,113.58	-26,285,686.65
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	41,287,210.95	57,287,210.95
39208	Хуримтлагдсан элэгдэл	-17,612,005.40	-22,813,790.07
393	Биет бус хөрөнгө	31,710,000.00	31,710,000.00
39301	Програм хангамж	715,000.00	715,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-715,000.00	-715,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	31,710,000.00	31,710,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II	244,800,462.60	278,104,046.06
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	676,500.00	00.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	676,500.00	00.00
414	Урьдчилж орсон орлого	676,500.00	00.00
41430	Барьцаа, дэнчингийн урьдчилж орсон орлого	676,500.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	244,123,962.60	278,104,046.06
51	Засгийн газрын хувь оролцоо	244,123,962.60	278,104,046.06
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	170,720,654.44	170,720,654.44

Булган аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

51101	Өмч: - төрийн	170,720,654.44	170,720,654.44
512	Хуримтлагдсан үр дүн	52,365,435.14	86,345,518.60
51210	Өмнөх үеийн үр дүн	52,365,435.14	52,365,435.14
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	33,980,083.46
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	21,037,873.02	21,037,873.02
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	244,800,462.60	278,104,046.06

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	529,853,717	660,945,688
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	18,684,517	28,619,488
120	Нийтлэг татварын бус орлого	18,684,517	28,619,488
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө	-	25,640,488
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал	-	2,979,000
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	18,684,517	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	18,684,517	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	511,169,200	632,326,200
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	471,169,200	622,326,200
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	471,169,200	622,326,200
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	40,000,000	10,000,000
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	40,000,000	10,000,000
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	513,855,480	626,965,605
21	УРСГАЛ ЗАРДАЛ	513,855,480	626,965,605
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	509,450,594	617,213,004
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	342,785,517	412,878,565
210101	Үндсэн цалин	264,120,608	236,715,778
210102	Нэмэгдэл	71,749,129	154,444,384
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,915,781	21,718,403
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,895,667	52,002,190
210201	Тэтгээрийн даатгал	39,340,343	49,477,037
210202	Тэтгэмжийн даатгал	812,581	631,138
210203	ҮОМШӨ-ний даатгал	650,065	504,910
210204	Ажилгүйдлийн даатгал	206,616	126,228
210205	Эрүүл мэндийн даатгал	1,686,061	1,262,276
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,979,600	29,019,847

Булган аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210301	Гэрэл, цахилгаан	2,153,969	3,157,815
210302	Түлш, халаалт	18,614,970	20,514,792
210303	Цэвэр, бохир ус	2,210,661	3,067,240
210304	Байрны түрээс	-	2,280,000
2104	Хангамж, бараа материалын зардал	24,202,525	38,437,249
210401	Бичиг хэрэг	9,234,970	12,966,100
210402	Тээвэр, шатахуун	8,250,000	8,950,000
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,504,605	3,561,623
210404	Ном, хэвлэл	129,700	373,800
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	967,650	665,600
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,115,600	9,315,777
210408	Бараа материал акталсны зардал	-	2,604,349
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,116,710	20,210,500
210604	Урсгал засвар	5,116,710	20,210,500
2107	Томилолт, зочны зардал	2,000,000	736,000
210702	Дотоод албан томилолт	2,000,000	736,000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,977,331	29,734,297
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,432,100	28,161,100
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000	-
210803	Даатгалын үйлчилгээ	961,200	1,224,000
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227,366	58,165
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000	44,000
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	231,000
210807	Газрын төлбөр	10,665	16,032
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	60,493,244	34,194,356
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	34,500,000	663,100
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,849,704	6,400,000
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	22,143,540	27,131,256
210904	Найдваргүй авлагын алдагдал	-	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,404,886	9,752,601
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,130,000	500,000
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,130,000	500,000
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,274,886	9,252,601
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,274,886	9,252,601
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	15,998,237	33,980,083
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	7,722,222	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	7,722,222	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(7,722,222)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	8,276,015	33,980,083

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	170,720,654.44	21,037,873.02	44,089,419.77	235,847,947.23
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	170,720,654.44	21,037,873.02	43,845,282.75	185,670,961.42
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	44,089,419.77	235,847,947.23
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	170,720,654.44	21,037,873.02	52,365,435.14	244,123,962.60
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	170,720,654.44	21,037,873.02	52,365,435.14	244,123,962.60
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	170,720,654.44	21,037,873.02	52,365,435.14	244,123,962.60
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	33,980,083.46	33,980,083.46
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	170,720,654.44	21,037,873.02	86,345,518.60	278,104,046.06

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	511,169,200	632,326,200
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	511,169,200	632,326,200
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	471,169,200	622,326,200
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	471,169,200	622,326,200
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	40,000,000	10,000,000
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	40,000,000	10,000,000
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	495,781,200	605,169,100
21	УРСГАЛ ЗАРДАЛ	495,781,200	605,169,100
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	491,376,314	594,739,999
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	342,785,517	412,878,565
210101	Үндсэн цалин	264,120,608	279,116,287
210102	Нэмэгдэл	71,749,129	113,312,064
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,915,781	20,450,215
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,895,667	52,002,190

Булган аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210201	Тэтгэврийн даатгал	39,628,543	40,104,205
210202	Тэтгэмжийн даатгал	812,581	2,974,497
210203	ҮОМШӨ-ний даатгал	650,065	2,379,597
210204	Ажилгүйдлийн даатгал	162,516	594,899
210205	Эрүүл мэндийн даатгал	1,641,961	5,948,991
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,979,600	29,019,847
210301	Гэрэл, цахилгаан	2,153,969	3,157,815
210302	Түлш, халаалт	18,614,970	20,514,792
210303	Цэвэр, бохир ус	2,210,661	3,067,240
210304	Байрны түрээс	-	2,280,000
2104	Хангамж, бараа материалын зардал	27,970,295	36,211,800
210401	Бичиг хэрэг	9,882,910	13,423,800
210402	Тээвэр, шатахуун	8,600,000	8,600,000
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,048,235	3,561,623
210404	Ном, хэвлэл	129,700	373,800
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,666,300	828,600
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,643,150	9,423,977
2105	Нормативт зардал	65,000	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	65,000	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,399,700	22,511,300
210604	Урсгал засвар	15,399,700	22,511,300
2107	Томилолт, зочны зардал	2,000,000	736,000
210702	Дотоод албан томилолт	2,000,000	736,000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,930,831	31,110,197
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,385,600	29,537,000
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000	-
210803	Даатгалын үйлчилгээ	961,200	1,224,000
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227,366	58,165
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000	44,000
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	231,000
210807	Газрын төлбөр	10,665	16,032
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,349,704	10,270,100
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,500,000	3,125,100
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,849,704	7,145,000

Булган аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,404,886	10,429,101
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	676,500
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	676,500
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,130,000	500,000
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,130,000	500,000
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,274,886	9,252,601
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,274,886	9,252,601
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	15,388,000	27,157,100
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	15,388,000	27,833,600
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	15,388,000	27,833,600
2200	Дотоод эх үүсвэрээр	15,388,000	27,833,600
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	15,388,000	27,833,600
7	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-15,388,000	-27,833,600
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)		-676,500
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	676,500	676,500
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	676,500	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	622,326,200	613,073,599
21	УРСГАЛ ЗАРДАЛ	622,326,200	613,073,599
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	621,826,200	612,573,599
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	422,084,500	412,878,565
210101	Үндсэн цалин	277,493,800	279,116,287
210102	Нэмэгдэл	122,499,000	113,312,064
210103	Унаа хоолны хөнгөлөлт	22,091,700	20,450,215
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,002,200	52,002,190
210201	Тэтгэврийн даатгал	36,488,300	40,104,205
210202	Тэтгэмжийн даатгал	3,878,500	2,974,497
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,102,800	2,379,597
210204	Ажилгүйдлийн даатгал	775,700	594,899
210205	Эрүүл мэндийн даатгал	7,756,900	5,948,991
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,021,400	29,019,847
210301	Гэрэл, цахилгаан	3,195,400	3,157,815

Булган аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210302	Түлш, халаалт	20,575,000	20,514,792
210303	Цэвэр, бохир ус	1,826,200	3,067,240
210304	Байрны түрээс	3,424,800	2,280,000
2104	Хангамж, бараа материалын зардал	31,211,800	31,211,800
210401	Бичиг хэрэг	8,423,800	8,423,800
210402	Тээвэр, шатахуун	8,100,000	8,600,000
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,086,000	3,561,623
210404	Ном, хэвлэл	409,200	373,800
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,000,000	828,600
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,192,800	9,423,977
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	48,670,000	48,670,000
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,000,000	9,000,000
210602	Тавилга	16,000,000	16,000,000
210604	Урсгал засвар	23,670,000	23,670,000
2107	Томилолт, зочны зардал	736,000	736,000
210702	Дотоод албан томилолт	736,000	736,000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,155,300	26,110,197
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	24,537,000	24,537,000
210803	Даатгалын үйлчилгээ	1,224,000	1,224,000
210804	Тээврийн хэрэгслийн татвар	103,200	58,165
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000	44,000
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	231,000	231,000
210807	Газрын төлбөр	16,100	16,032
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,945,000	11,945,000
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,800,000	4,800,000
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,145,000	7,145,000
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	#REF!	#REF!
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000	500,000
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000	500,000
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	622,326,200	622,326,200
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	622,326,200	622,326,200
131001	Улсын төсвөөс санхүүжих	622,326,200	622,326,200
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	676,500
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	21	21
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	6	6
620003	Үйлчлэх ажилтан	14	14
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	21	21
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	1	1
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	7	7
650003	Ажлын албаны албан хаагч (АА)	3	3
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	10	10

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

		/ төгрөгөөр /
Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,000,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,000,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,000,000.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,000,000.00
210401	Бичиг хэрэг	5,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,000,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	10000000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,000,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Булган аймгийн Прокурорын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Бэйкер тилли Далайван аудит ХХК-ийн Орхон аймаг дахь салбар ахлах аудитор, захирал Д.Мягмарсүрэн, аудитор Б.Пүрэвсүрэн нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Булган аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь “Далай ван” аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн ...дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Булган аймгийн Прокурорын газар нь 2021 онд удирдлага зохион байгуулалтын чиглэлээр хийсэн ажлууд нь Прокурорын байгууллагын дэвшүүлсэн зорилт, Улсын ерөнхий прокурорын албан даалгаврыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн бөгөөд төлөвлөсөн ажлын чанар үр дүнд анхаарч ажилласнаар зохих түвшинд хүрч ажилласан гэж дүгнэж байна.

Тус аймгийн прокурорын газраас мэргэжлийн байгууллагатай хамтран дотоод ажил болон хяналтын ажлын талаар тус бүр 1 судалгаа хийлээ. "Ажлын байрны шинжилгээ, сэтгэл ханамжийн судалгаа"-г хийснээр шинэ залуу прокурор, ажилтнуудад түргэн хугацаанд ажиллах орчин нөхцөлдөө дасах, үүрэг хариуцлагаа бүрэн ухамсарлах, гүйцэтгэлийн хяналт сайжрах нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна. Мөн Мал хулгайлах гэмт хэргийн шалтгаан нөхцөлийн талаар криминалоги судалгаа хийснээр тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил бодитой үр дүн гарахуйц ажил болно гэж дүгнэж байгаа.

Прокурор, ажилтнуудын суралцах орчин нөхцөл эрс сайжирсан. Тухайлбал: Сургалтын өрөөний тохижилтыг орчин үеийн шаардлагад нийцүүлж засвар хийлгэж тохижуулсан, шаардлагатай тоног төхөөрөмжөөр бүрэн хангасан, прокурор, ажилтан бүрийн компьютерт камер суурилуулж алсын зайн сургалтуудад хамрагдах, хяналтын прокурорууд шүүх хуралдаанд өрөөнөөсөө оролцох боломж нөхцөлийг бүрдүүлсэн.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорилт гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагад дотоод чанарын баталгаажуулалт, статистик хариуцсан ахлах ажилтан ажилладаг хэдий ч тухайн ажилтан чиг үүргээ хэрэгжүүлснээр тодорхой үр дүн гарсан эсэх нь тодорхойгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 622,326.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 6,223.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 4,356.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Булган аймгийн Прокурорын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 33,303,583 мянган төгрөгөөр буюу 0.88 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлттэй гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	
Бараа материал	11,534.1	19,171.3	7,637.2
Үндсэн хөрөнгө	232,589.9	258,932.7	26,342.9
Нийт хөрөнгө	244,800.5	278,104.0	33,303.5
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	244,800.4	278,104.04	33,303.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	244,800.4	278,104.04	33,305.5

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 278,104.04 мянган төгрөг болж 33,303.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Булган аймгийн Прокурорын газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлого өмнөх оноос 131,091.9 мянган төгрөгөөр буюу 19,8 хувиар, нийт зардал өмнөх оноос 113,110.2 мянган төгрөгөөр буюу 18 хувиар тус тус өссөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Булган аймгийн Прокурорын газар нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 610,800.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 610,800.0 мянган төгрөгөөр тооцож, төлөвлөн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Тус байгууллагаас хүргүүлсэн төсвийг тодотгол оруулан 622,326.0 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр 622,326.2 мянган төгрөгийг улсын төсвөөс, урсгал үйл ажиллагаанд 613,073.6 мянган төгрөгийг зарцуулж, 9,252.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 613,073.6 мянган төгрөг буюу 98,5 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг 9,205.9 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 1.5 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж зардлыг 45.1 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Булган аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс 10 сая төгрөгийн санхүүжилтийг нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авсан байна.

Үүнээс 5 сая төгрөгийг Мал хулгайлах гэмт хэргийн шалтгаан нөхцөлийн талаарх судалгааны ажилд, үлдэгдэл 5 сая төгрөгийг судалгааны ажлыг ном болгон хэвлүүлэхэд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудитын хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант хугацаанд Ажилчдад бэлнээр олгосон 500.0 мянган төгрөгөөс нийгмийн даатгал, татвар тооцож олгоогүй байна. 230.0 мянган төгрөгийн тэмцээн уралдааны шагналаас 5 хувийн ХХОАТ суутгаагүй байна. ХХОАТ-ын тухай хуулийн 21.1.Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд зааснаар тодорхойлсон орлогын дүнд 10 хувиар тооцож, албан татвар ногдуулна. 21.2.2.энэ хуулийн 19.1.1-д заасан орлогын дүнд 5 хувиар татвар ногдуулна гэсэн заалтуудын дагуу хувь хэмжээгээр татвар шимтгэлийг тооцох. Бараа материалын орлого зарлагын баримт болон шаардах хуудас тамга, тэмдгээр баталгаажаагүй, зарим анхан шатны баримтын иж бүрдэл дутуу гүйлгээ хийгддэг байна. Материалын зардалд 60.0 мянган төгрөг анхан шатны баримтгүй гүйлгээ хийгдсэн байна. Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримт, импортын бараанд татвар ногдуулж, гаалийн байгууллагад төлсөн тухай баримтаар баталгаажсан байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасны дагуу иж бүрэн баримтаар гүйлгээг хийж хэвших. Мөн Шилэн дансанд 1-8 сард цалингаас бусад таван сая төгрөгөөс дээш орлого зарлагын мөнгөн гүйлгээний мэдээг хугацаа хоцроон мэдээлсэн

байна. Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1.мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх; 4.1.3."тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалтын дагуу хугацаанд нь мэдээлж байх гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Булган аймгийн Прокурорын газар нь 2021 онд нийт 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 141 мэдээллийг хугацаандаа, 8 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Аудитын явцад цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш орлогын 8 гүйлгээ хугацаа хоцорч мэдээлснийг зөвлөмж болгосон болно.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Бараа материалын орлого зарлагын баримт болон шаардах хуудас тамга, тэмдгээр баталгаажуулахгүй, зарим анхан шатны баримтын иж бүрдэл дутуу гүйлгээ хийгддэг байна. Материалын зардал 60.0 мянган төгрөг анхан шатны баримтгүй гүйлгээ хийгдсэн нь Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримт, импортын бараанд татвар ногдуулж, гаалийн байгууллагад төлсөн тухай баримтаар баталгаажсан байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасны дагуу иж бүрэн баримтаар гүйлгээг хийж хэвших. Мөн ажилчдад бэлнээр олгосон 500.0 мянган төгрөгөөс нийгмийн даатгал, татвар тооцож олгоогүй байна. 230 мянган төгрөгийн тэмцээн уралдааны шагналаас 5 хувийн ХХОАТ суутгаагүй нь ХХОАТ-ын тухай хуулийн 21.1.Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд зааснаар тодорхойлсон орлогын дүнд 10 хувиар тооцож, албан татвар ногдуулна. 21.2.2.энэ хуулийн 19.1.1-д заасан орлогын дүнд 5 хувиар татвар ногдуулна гэсэн заалтуудын дагуу хувь хэмжээгээр татвар шимтгэлийг тооцох буюу холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 8,000.0 мянган төгрөгийн 1 зөвлөмжийн хэрэгжилтийг 100 хувьтай хангуулсан байна.

Хүснэгт . Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	хувь
Акт	-	-	-	-	-	-	-
Албан шаардлага	-	-	-	-	-	-	-
Зөвлөмж	1	8,000.0	1	8,000.0	-	-	-
Нийт дүн	1	8,000.0	1	8,000.0	-	-	-

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал, урсгал засварын зардлын төлөвлөлт, гүйцэтгэл анхаарал татахаар бөгөөд бусад чухал асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 384,285.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 271,398.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 104,194.4 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 8,692.9 мянган төгрөгийн алдаа зөрчилд 4 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Тайлант оны санхүүгийн тайлангийн аудитад залруулсан алдаа байхгүй.

4.2 Акт

Бараа материалын орлого зарлагын баримт болон шаардах хуудас тамга, тэмдгээр баталгаажуулахгүй, зарим анхан шатны баримтын иж бүрдэл дутуу гүйлгээ хийгддэг байна. Материалын зардал 60.0 мянган төгрөг анхан шатны баримтгүй гүйлгээ хийгдсэн байна. Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримт, импортын бараанд татвар ногдуулж, гаалийн байгууллагад төлсөн тухай баримтаар баталгаажсан байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасны дагуу иж бүрэн баримтаар гүйлгээг хийж хэвших гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн акт:

Цахим баримтаар гүйлгээг хийж хэвших, анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлэх.

4.3 Албан шаардлага

Тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар гаргасан алдаа зөрчилд албан шаардлага хүргүүлээгүй болно.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Ажилчдад бэлнээр олгосон 500.0 мянган төгрөгөөс нийгмийн даатгал, татвар тооцож олгоогүй байна. 230 мянган төгрөгийн тэмцээн уралдааны шагналаас 5 хувийн

ХХОАТ суутгаагүй байна. Энэ нь ХХОАТ-ын тухай хуулийн 21.1.Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд зааснаар тодорхойлсон орлогын дүнд 10 хувиар тооцож, албан татвар ногдуулна. 21.2.2.энэ хуулийн 19.1.1-д заасан орлогын дүнд 5 хувиар татвар ногдуулна гэсэн заалтуудын дагуу хувь хэмжээгээр татвар шимтгэлийг тооцох зөрчсөн байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Хувь хүнээс авч байгаа ажил үйлчилгээний хөлсийг олгохдоо холбогдох хуулиудын дагуу шимтгэл, татварыг тооцож олгож байх

2. Шилэн дансны хэрэгжилттэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Шилэн дансанд 1-8 сард цалингаас бусад таван сая төгрөгөөс дээш орлого зарлагын мөнгөн гүйлгээний мэдээг хугацаа хоцроон мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1.мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх; 4.1.3."тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалтын дагуу хугацаанд нь мэдээллэж байх зөрчсөн байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Хугацаанд нь үнэн зөв, бүрэн мэдээлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Булган аймгийн Прокурорын газар	3	790.0			1	60.0			2	730.0

АУДИТЫН ТАЙЛАНГ

БЭЛТГЭСЭН:

“БЕЙКЕР ТИЛЛИ ДАЛАЙВАН АУДИТ” ХХК-ИЙН ОРХОН АЙМАГ ДАХЬ САЛБАРЫН АУДИТОР:  Б.ПҮРЭВСҮРЭН

ХЯНАСАН:

ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР, ЗАХИРАЛ :  Д.МЯГМАРСҮРЭН

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН АУДИТЫН МЕНЕЖЕР:  Ж.ЭНХЦООДОЛ

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Б.АНХБАЯР